



№09 (160)

2024 оны 09-р сар

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:

**ХАМТРАН АЖИЛЛАХ
САНАМЖ БИЧИГТ
ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА**

Монгол-Германы
хамтарсан ашигт малтмал
технологийн их сургууль

2,3-р нүүрт

**Илтгэлийн
уралдаан-2024
удирдамж**

4-р нүүрт

**2024 ОНЫ 8-Р
САРЫН ТЭЗҮ**

5-р нүүрт

**2024 ОНЫ 8-Р САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

6-р нүүрт

**ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН
СТАНЦЫН ДЭРГЭДЭХ
ЭРЧИМ ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОРОО**

7-р нүүрт

**УУШГИНЫ АРХАГ
БӨГЛӨРӨЛТ ӨВЧИН**

8-р нүүрт

"ЭРЧИМ ХҮЧНИЙ РЕФОРМ" УУЛЗАЛТ БОЛЛОО

2024 оны 09-р сарын 06-нд МУ-ын Шадар сайд Х.Доржханд тэргүүтэй Эрчим хүчний реформыг хэрэгжүүлэх Засгийн газрын дэд хорооныхон манай компанийн үйл ажиллагаатай танилцлаа.

Шадар сайд Х.Доржханд Эрчим хүчний реформын тухай, Эрчим хүчний хуулийн шинэчлэл, өөрчлөлтийг хаврын чуулганаар оруулах тухай уулзалтад оролцсон хүмүүст мэдээлэл өглөө. Компанийн Гүйцэтгэх захирал компанийн ажил, хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх асуудлуудыг Дэд хорооны гишүүдэд дэлгэрэнгүй танилцуулж, асуулт хариулт, санал хүсэлт тавьж, уулзалт амжилттай болж өндөрлөлөө.

МУ-ын Ерөнхий сайдын 2024.08.16-ны 37 тоот захирамжаар Эрчим хүчний реформыг хэрэгжүүлэх Дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан билээ. Үүнд :

- Дэд хорооны дарга: Х.Доржханд, МУ-ын шадар сайд, УИХ-ын гишүүн;
- Дэд хорооны дэд дарга: М.Энхцэцэг, УИХ-ын гишүүн;
- Дэд хорооны нарийн бичгийн дарга: Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайд, УИХ-ын гишүүн;
- Дэд хорооны гишүүд: Ч.Анар, УИХ-ын гишүүн, Ж.Золжаргал, УИХ-ын гишүүн, Б.Найдалаа, УИХ-ын гишүүн, С.Цэнгүүн, УИХ-ын гишүүн, Д.Энхтуяа, УИХ-ын гишүүн, Б.Жамбал, МУ-ын Ерөнхий сайдын зөвлөх, Э.Түвшинчулуун Эрчим хүчний зохицуулах хорооны дарга, Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, В.Энхбаатар, Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга, Л.Жамбаа, МУ-ын шадар сайдын зөвлөх, Д.Ганхуяг, МҮХАҮТ-ын дэргэдэх ЭХЗ-ийн дарга, Ц.Түмэнцогт, Монголын бизнесийн зөвлөлийн УЗ-ийн дарга, Р.Ганжуур, Монголын эрчим хүчний инженерүүдийн холбооны тэргүүн, С.Наранцогт, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал.



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, sxa@tpp4.mn эсвэл

СХА-нд файлаар болон бичгээр өгч болно.



www.tpp4.mn



ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Налайх дүүрэгт байрлах Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургууль (МГТИС), Дулааны IV цахилгаан станц ТӨХК хоорондын хамтын ажиллагааны санамж бичгийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр байгууллаа.

Санамж бичигт ДЦС-4 ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, МГТИС-ийн ректор Проф.Др. Б.Батцэнгэл нар гарын үсэг зурж баталгаажуулав.



Энэхүү санамж бичгийн хүрээнд сургалт судалгаа, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд бүрэн нийцсэн, үйлдвэрлэлийн мэдлэг, дадлага, туршлага бүхий үндэсний мэргэжилтнийг бэлтгэх, станцын үнсэнд агуулагдах газрын ховор элементийн судалгааны төсөл хэрэгжүүлэх, аж үйлдвэрийн болон боловсролын салбарт тулгамдаж буй асуудлыг хамтран шийдэх, сургалт судалгааны үйл ажиллагаан дахь аж үйлдвэрийн салбарын оролцоог

дэмжих, нэмэгдүүлэх зорилгын дагуу харилцан тохиролцсон юм.

Хамтын ажиллагааны хүрээнд:

- ДЦС-4 ТӨХК-ийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан бакалаврын дараах мэргэжил дээшлүүлэх богино хугацааны болон урт хугацааны сургалтыг МГТИС болон ХБНГУ-ын их сургууль, сургалт судалгааны лабораториудад санал болгох, хамруулах
- Хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх
- Цахилгаан шүүлтүүрийг шинэчлэх судалгаа хийх
- Үнснээс ялгарах газрын ховор элементийн талаарх судалгаа хийх
- Сургалт, судалгааны мэдээлэл харилцан солилцох
- Оюутан, багш нарыг танилцах аялал болон үйлдвэрийн дадлагад хамруулах
- Лабораторийн ажилтнуудын хамтын ажиллагаа, тоног төхөөрөмжийн харилцан хэрэглээг дэмжих Санамж бичиг байгуулах ажлын хүрээнд "ДЦС-4" ТӨХК-ийн төлөөлөгчид МГТИС-ийн лаборатори болон сургалтын танхимуудаар зочилж үйл ажиллагаатай танилцаж Герман улсын технологийг эрчим хүчний салбарт цаашид хэрхэн нэвтрүүлэх талаар тус сургуулийн эрдэмтэн багш нартай санал бодлоо солилцсон юм.

Төгсгөлд нь "ДЦС-4" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг МГТИС-ийн болон Налайхын политехникийн коллежийн оюутан залууст Монгол улсын эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, тулгарч байгаа асуудлуудын талаар лекц уншив. Мөн лекцийн хүрээнд оюутан залуустай чөлөөтэй ярилцаж, мэргэжилдээ эзэн болохын давуу тал, хэлний мэдлэг, ажлын туршлага, хувь хүний хөгжил зэрэг сэдвээр оюутнуудад зөвлөмж өгөв.





МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ



МГТИС нь Монгол, Герман хоёр улсын засгийн газрын санаачилгаар 2013 онд үүсгэн байгуулагдсан, ХБНГУ-ын болон олон улсын, үндэсний дээд боловсролын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, олон улсын стандартад нийцсэн, шилдэг сургуулиуд, туршлагад суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг сургууль юм.

Тус сургууль нь Монгол, Германы эрдэмтэн, багш, мэргэжилтнүүдээр багаа бүрдүүлж, сургалт, судалгааны ая тухай орчин нөхцлийг бүрдүүлж чадсан, Монгол Улсдаа анхны хотхон (campus) сургууль ажээ. МГТИС-ийн сургалт англи хэл дээр явагддаг бөгөөд Герман хэлийг сонгон суралцах боломжтой.

МГТИС нь дараах бакалаврын (4 жил) болон магистрын (2 жил) хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна:

- Уул уурхайн боловсруулалтын инженерийн бакалавр
- Механик инженерийн бакалавр
- Хүрээлэн буй орчны инженерийн бакалавр
- Эрчим хүч, цахилгааны инженерийн бакалавр
- Эдийн засагч инженерийн бакалавр
- Мехатроник инженерийн бакалавр

Магистрын хөтөлбөр

- "Байгалийн нөөц, технологи"-ийн шинжлэх ухааны магистр
- Эрдэс баялагийн эрчимт өсөлт, боловсруулалтын магистр /Германы Фрайбергийн Технологийн Их Сургууль, Австрийн Лебен хотын Монтаны Их сургуультай хамтарсан/





Сургалтын хөтөлбөрүүдийнхээ хүрээнд МГТИС нь шинжлэх ухааны өндөр мэдлэг, олон талт байдал, насан туршийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт ба бизнес эрхлэлт, аж үйлдвэрлэлийн хамаарал, салбар хоорондын сэтгэлгээ, нийгмийн хариуцлага, дэвшилтэт судалгаа, инновацийг Монголын нийгмийн сайн сайхны төлөө чиглүүлэн ажилладаг байна. МГТИС-ийн сургалтын хөтөлбөр нь 2019 онд Европын холбооны "ACQUIN" байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн.

МГТИС нь Германы инженерийн боловсролын стандартыг хангасан сургалтын хөтөлбөрөөр суралцуулах, амжилттай суралцаж буй оюутнуудаа сургалтын төлбөрөөс чөлөөлөх, семестр солилцооны хөтөлбөр, компанийн нэрэмжит тэтгэлэг зэрэг олон төрлийн тэтгэлэгт хамрагдах боломжийг олгох, зуны амралтаар оюутнуудаа ХБНГУ (Фрайбергийн Технологийн Их Сургууль), БНХАУ (Шу Жөу хотын уул уурхайн их сургууль) зэрэг улсуудад зуны сургалтад хамруулах, төгсөгчдөө ажлын байранд бүрэн бэлтгэгдсэн мэргэжилтэн болгодог зэрэг олон давуу талтай, Монгол Улсын дээд боловсролын шинэчлэлийн загвар сургууль болохоор зорин ажиллаж байна.

Хамтын ажиллагаа хариуцах ажилтнаар "ДЦС-4" ТӨХК талаас СХА-ны дарга Г.Галбадрах /99180536/, МГТИС талаас Проф. Др. П.Ариунболор /99015671/.

<https://www.facebook.com/gmit.edu>

<https://www.gmit.edu.mn/>





КОМПАНИЙН АЖИЛТНУУДЫН ДУНД УЛАМЖЛАЛ БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ 12 ДАХЬ УДААГИЙН ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Компанийн алба, хэлтэс, цех, нэгж, хэсгүүдэд байгаа техник, технологийн хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, олон улсад нэвтэрч буй шинэ техник, технологийг компанид нэвтрүүлэх, өөрсдийн хийсэн судалгааны ажлын үр дүнг хамт олонд хүргэж мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах, судалгаа шинжилгээний ажилд сонирхолтой ажилтны идэвх санаачлагыг дэмжих, өрнүүлэх үндсэн зорилготой.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Компанийн хэтийн зорилт, өнөөгийн үйл ажиллагааны хүрээнд инноваци шингэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, шинэ техник технологийг нэвтрүүлэхэд шаардагдах асуудлыг судлан, улмаар үйлдвэрлэлд нэвтрүүлэх, станцын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх нөхцлийг бий болгоход оршино.

ГУРАВ. ИЛТГЭЛИЙН СЭДВИЙН ЧИГЛЭЛ, НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Илтгэлийн сэдвийн чиглэл:

1. Шинэ ажил үйлчилгээ гаргах
2. Шинэ бүтээгдэхүүн бий болгох
3. Шинэ техник, технологи нэвтрүүлэх
4. Явцуу шат дамжлагыг илрүүлэх, арилгах
5. Ажилдаа нэвтрүүлсэн ололт амжилтыг нээн илрүүлэх
6. Асуудал дэвшүүлсэн гэх мэт чиглэлүүдээр илтгэгч илтгэлээ бэлтгэж оролцоно.

Шилдэг, шинэ санал санаачлагын ажлыг компанид нэвтрүүлэх ажлын эхний шалгуур нь тухайн илтгэл байх бөгөөд гаргасан шинэ санаагаа ажил болгох нөхцлийг бүрдүүлж өгнө.

Мөн алба, хэлтэс, цех, нэгжийн жилийн ажлын зорилго, зорилтоо биелүүлэх, ажил хэрэг болгох ажлын биелэлтийн үндсэн шалгуур нь тухайн илтгэл байх бөгөөд асуудалд тооцоо судалгаатай, шинжлэх ухаанчаар хандах үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Илтгэлийн уралдааны нөхцөл:

Илтгэлийн уралдааныг Судалгаа Хөгжлийн Албанаас зохион байгуулах бөгөөд компанийн бүх ажиллагсад өөрсдийн бэлтгэсэн илтгэлээрээ нээлттэй оролцох боломжтой. Илтгэлийн уралдаанд ажилтан дангаараа болон баг, хамт олноороо зохион байгуулалттай оролцож болно.

Илтгэлийн уралдааныг хоёр үе шаттай дүгнэн явуулна. Эхний шатанд ирүүлэх материалыг 2024 оны 09-р сарын 20-ны 09-15 цагийн хооронд СХА-ны 313 тоотод хүлээн авна.

Уралдааныг дүгнэх комисс, ирүүлсэн илтгэлүүдтэй танилцаж, шалгарсан илтгэгч нарт ажлын 14 өдрийн өмнө мэдэгдэнэ.

Уралдааны дараагийн шатанд тэнцсэн илтгэлийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Дөл танхимд зохион явуулна.

Илтгэлийн материалын шаардлага:

Илтгэлийн уралдаанд оролцож буй материалууд урд өмнө Техникийн Зөвлөлийн Хуралаар орж хэлэлцэгдэж, компанид ажил хэрэг болж, нэвтэрч эхлээгүй шинэ санаа, шинэлэг бүтээл байх шаардлагатай.

Уралдаанд оролцох илтгэл нь А4 хэмжээс бүхий цаасан дээр 20 хүртэл нүүр байж болох ба танилцуулах хугацаа 15 минутаас ихгүй байна.

Баримт бичгийн бүрдлүүд нь хэвлэмэл хуудсанд тавигдах нэгдмэл шаардлага, стандартын дагуу хийгдсэн байна. Үүнд:

- Хуудасны дээд, доод талаас 3 см, баруун зүүн талаас 2,5 см-ийн зайтай
- Үсгийн фонд: Arial
- Үсгийн өндөр : 12 point
- Мөр хоорондын зай: 1,5 мөр

Илтгэлийн бүтэц нь: Оршил, Үндсэн хэсэг (а. Судалгааны хэсэг, б. Эдийн засгийн тооцоо, в. Дүн шинжилгээ) Дүгнэлт, Хавсралт хэсэг.

ЖИЧ: Түлхүүр үг, тайлбар материал, арга зүй, үр дүн, график, зураг, хүснэгт, ашигласан ном зохиол, эх материал гэх мэт зүйлийг оруулсан байх.

Эхний шатанд оролцох илтгэлийг MSOffice Word программ дээр бэлтгэж заасан хугацаанд ирүүлсэн байна.

Илтгэгч өөрийн овог нэр, цээж зураг, боловсрол, төгссөн сургууль, хашиж буй албан тушаал, цех нэгж (алба, хэлтэс, цех, нэгж), холбоо барих утас, e-мэйл хаягийг тодорхой бичсэн анкетийг бөглөж хавсралтаар ирүүлнэ. Дараагийн шатанд танилцуулагдах материалаа MS Office Powerpoint программ дээр бэлтгэн, мөн заасан хугацаанд ирүүлсэн байна. Хугацаа хоцорч ирүүлсэн материалыг хүлээн авах боломжгүй болно.

ДӨРӨВ. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ

I шатны шалгаруулалт: Ирүүлсэн бүх илтгэлийг үнэлэхдээ доорх үзүүлэлт тус бүрээр оноо өгч болзол хангасан илтгэлүүдийг 2-р шатанд шалгаруулан хэлэлцүүлэхээр үлдээнэ.

- Илтгэлд тавигдах шаардлага хангасан эсэх 1 – 5 оноо
- Судалгааны арга зүй, онолын тооцоолол, судлагдсан байдал 1 – 10 оноо
- Судалгаа, шинжилгээний ажлын гүйцэтгэл 1 – 5 оноо
- Эдийн засгийн үр ашиг, хэмнэлтийн тооцоо хийгдсэн байдал 1 – 15 оноо
- Судалгааны ажлын ач холбогдол, үр дүн 1 – 20 оноо

Дундаж оноогоор эхний 8 байрт шалгарсан илтгэлийг дараагийн сонсох шатанд шалгаруулан оролцуулна.

II шатны шалгаруулалт: Нийтэд танилцуулагдах илтгэлүүдийг доорх үзүүлэлтүүдээр үнэлгээ өгч шалгаруулна.

- Сэдвийн агуулга ач холбогдол 1 – 8 оноо
- Байгууллагад хэрэгжүүлэх шаардлагатай эсэх 1 – 8 оноо
- Судалгааны ажлын гүйцэтгэл 1 – 8 оноо
- Асуултанд оновчтой хариулж байгаа эсэх 1 – 8 оноо
- Илтгэлд бэлдсэн байдал, илтгэх ур чадвар 1 – 8 оноо

Шүүгчдийн үнэлгээгээр дундаж оноогоор хамгийн их оноо авсан дарааллаар илтгэлийг шалгаруулна.

ТАВ. УРАЛДААНЫГ ШАЛГАРУУЛАХ КОМИСС

Комиссын даргаар компанийн ерөнхий инженер, гишүүдээр ХА, СХА-ны дарга нар мөн ШУТИС, ЭХС-аас цахилгаан, дулааны мэргэжлийн, эрдмийн цол зэрэгтэй 2 багш байна. Комиссын нарийн бичгийн даргаар СХА-ны ЗБТСХ-ийн патентын мэргэжилтэн оролцон ажиллана.

ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Тэргүүн байр (нэг)	Өргөмжлөл	2 500 000₮
Дэд байр (нэг)	Өргөмжлөл	2 000 000₮
Гутгаар байр (нэг)	Өргөмжлөл	1 500 000₮
Шагналт байр (нэг)	Өргөмжлөл	1 000 000₮
Тусгай шагнал (дөрөв)	Батламж	250 000₮



2024 ОНЫ 8-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Диспетчерийн төлөвлөгөөт даалгаварыг **2172.264** мян.кВтц-аар давуулан биелүүлсэн. Энэ сард диспетчерийн графикийн зөрчилгүй ажиллалаа. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал **360** МВт, дээд ачаалал **488** МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт, %
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	291.7	293.9	+2.2	100.8%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	173.7	173.7	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - **100.8%**, ДЭХ - **100.0%** биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц
66	2172.264	27	335.75	-	-	488	360	2172.264

СПОТ зах зээлийн талаар

Энэ сард манай станц доголдолгүй ажиллаж СПОТ арилжаанаас цахилгаан эрчим хүч худалдаж аваагүй. СПОТ арилжааны зах зээл **232,54** мян.кВтц буюу **10,3** сая.төгрөгний цахилгаан худалдсан. Өссөн дүнгээр **112,9** сая.төгрөгийн авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс **1,0** сая.кВтц-аар давуулан **100,3%**-н биелэлттэй, оны эхнээс **58,6** сая.кВтц-аар давж, **102,1%**-ийн биелэлттэй байна. Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 8-р сартай харьцуулбал **8,3** сая.кВтц буюу **2,9** %-н өсөлттэй байлаа. Дулааны эрчим хүчний түгээлт **7,7** мян.Гкал-аар буурч **95,7%**-н биелэлттэй, оны эхнээс үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө **10,8** мян.Гкал-аар, үүнээс "УБДС" ХК-д нийлүүлэх дулаан **8,5** мян.Гкал-аар тасарч байна. Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 8-р сартай харьцуулбал **4,9** мян.Гкал буюу **2,9%**-н өсөлттэй байлаа.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд **6** зуух, **6** турбин оролцсон. Сарын дунджаар **4,99** зуух, **5,0** турбинтэй ажиллаж **1** зуух бэлтгэлд, турбин бэлтгэлгүй байлаа. 2024 оны графикт их дунд засвар хийгдсэн болон засварт зогссон тоноглолуудын дурдвал:

Зуухнуудын хувьд: Зуух №4 29/Ү1 -өөс их засварт, Зуух №8 -г 9/Ү1 -өөс дунд засварт зогсоож засвар үргэлжилж байна.

Турбинуудын хувьд: Турбин №5 8/ҮIII -аас дунд засварт зогссон. Турбин №6 дунд засвар үргэлжилж байна.

Туслах тоноглолын талаар

Станцын туслах тоноглол, дулаанжуулалтын тоног төхөөрөмжүүд нь станцын ажиллагаанд хүндрэл учруулах саатал, гэмтэл гаргаагүй байна. Тэжээлийн цахилгаан насосыг 23 удаа зогсоосны 20 удаа нь горимтой холбоотой зогсолт байлаа. Сарын дунджаар 4,51 насостай ажилласан.

Мазутын зарцуулалт

Энэ сард **120** тонн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс **61** тонн мазут түлж **59** тонн мазут хэмнэсэн. Тайлант хугацаанд **3** удаагийн хүйтэн галлагаанд **60** тн мазут түлсэн. Нэг хүйтэн галлагаанд дунджаар **20** тн мазут зарцуулсан байна.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	153.536	157.579	+4.043	102.6%

Шивээ-Овоо	мян.тн	125.0	120.645	-4.355	96.5%
Бүгд	мян.тн	278.536	278.224	-0.312	99.9%

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - **0,03** гр/кВтц-аар, дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - **0,06** кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс **17** тн жишмэл түлш буюу **37** тонн бодит түлш /илчлэг **3178** ккал/кг/ хэмнэсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ -аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг **0,26%** буюу **868.987** мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	7-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	29.73	29.03
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	4.59	4.48
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	8.95	8.74
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	1.39	1.35
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.64	0.63

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг **1,65%** - аар буюу **22937** тонноор хэмнэсэн. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт **20440** тонноор буурлаа. Осмосын халаагч уурын зарцуулалт **3026** тн байлаа.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

☒ Турбинд - **15824** м³ ус

☒ Зууханд - **402** м³ өгсөн

БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - **3585** м³ байлаа.



2024 ОНЫ 8-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2024 оны 8-р сард станцын хэмжээний аварга, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 3 бүртгэгдсэнээс зуух 2 удаа, турбин 1 удаа зогссон.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2023 оны 8-р сар	2024 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2024 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2024 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2024 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2024 оны 8-р сар
1	Зуух	2	-	-	2	-	-	1	-	3	2
2	Турбин	-	-	1	1	-	-	1	-	2	1
	Дүн	2	-	1	3	-	-	2	-	5	3

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ЦЦ-1 (12.000 ₮), Бүгд-1 (12,000 ₮)
- Тоног төхөөрөмж, сэлбэг материалыг ашиглалтаас хасах акт: ДХХАЦ-2 (0 ₮), Бүгд-2 (0 ₮)

Нийт 2 ширхэг (12,000 төгрөг) акт тогтоогдсон.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)	Ажлын байрны халуун (12-30 °C)	Ажлын байрны чийглэг (30-60 %)	Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2024 оны 08-р сар	2024 оны 08-р сар	2024 оны 08-р сар	2023 оны 08-р сар	2024 оны 08-р сар	
1	ТДЦ	85.2	26.6	50.4	7.77	9.39	+1.62
2	ЗЦ	81.2	29.7	43.1	6.44	6.85	+0.41
3	ТЦ	75.1	29.2	42.8			Станцын дундаж тоосролт
4	ЦЦ	52.7	39	26			
5	Хими	74.6	24.9	50.7			
6	Механик	91.4	25.5	50.8			

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	120 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	126 ажлын байранд эргэлт шалгалтын маршрутын дагуу хяналт тавьсан.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	Зуух №2,4,6, ТА-3,6-ийн их засвар, гадны гэрээт гүйцэтгэгч компаниудын засварын ажлуудад тухай бүр хяналт хийсэн.

2. Сургалт, зааварчилгаа

1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	125 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	23 ажилтан зааварчилгаа өгч аюул, эрсдэл, хөдөлмөрийн нөхцлийн талаар ярьж өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	11 ажилтнаас шалгалт авсан.
4	Бусад сургалтын талаар	100%	Зэрэг ахих болон жинхлэх 20 ажилтнаас шалгалт авсан.

3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар

1	МХЕГ ХАБУЛ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих	100%	Хяналт тавьж байгаа. ХАБУЛлабораторид ундны ус - 3 цэгээс, арчдас - 10 ш, агаар -2 цэгээс, хоол - 3 дээж шинжилгээнд өгсөн. Хариу ХЭВИЙН гарсан.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх	100%	Үндсэн 6 цехд хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийгдсэн.
3	Ундны усны шүүлтүүр солих ажилд хяналт тавьсан талаар	100%	Хяналт тавьж байгаа
4	Ариутгал халдваргүйтгэл шавьж мэргэчийн устгал хийсэн талаар	100%	Хяналт тавьж байгаа
5	Тоосролын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн. 4-р зуух буулгах үед хэмжилт хийсэн 68.8 мг/м³ гарсан. Зөвшөөрөгдөх хэмжээнээс ИХ байсан.

4. Бусад ажлын талаар

- Эрчим хүчний салбарын хяналтын ажилтнуудын зөвлөлгөөнөөс гарсан зөвлөмжийн биелэлт гаргаж явуулсан.
- ЭЗЦГ-н ажилтнуудтай гарч болзошгүй ослын талаар танилцуулга хийж зааварчилгаа өгсөн.
- Гамшгийн эрсдэлийн үнэлгээ үнэлгээний компанаар хийлгэсэн
- ЭХ-ны баяртай холбоотой зааварчилгаа боловсруулж цех, нэгжүүдэд тараалт хийсэн.
- Ослын дүн шинжилгээний хурал хийсэн.
- ОМД-3 цех нэгжүүдэд түгээлт хийсэн.
- ОМД-2 биелэлт гаргасан.
- Бөөрөлжүүтийн цахилгаан станцаас ирсэн ажилтнуудийг дагуулж танилцуулга хийсэн.
- ТЭЗХ-т ISO 45001-2018 стандартын дотоод аудитын сургалтанд хамрагдсан баримт гаргаж өгсөн.
- Станцийн ОЭД-г ЦЦ-ийн Өмнөд 1 ХХБ-ын 0,4 кв-н "Сайхан хараа" ХХК-ийн тэжээлийг таслуулж бодитоор хийлээ. ЗХНА, Эмнэлэгийн хэсэг оролцсон.
- БМА, ХЦ, МЦ -д ISO 45001:2018 стандартын дотоод аудит хийсэн.
- ЭХЯ-ны 7/1242 албан даалгаврын гүйцэтгэл гаргасан.
- Хүнсний агуулах болон ЭЗЦГ-т хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийв.

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦЫН ДЭРГЭДЭХ ЭРЧИМ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО




"ДЦС-4" ТӨХК-ийн нийт ажилтнууддаа энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэндээ Дөрөвдүгээр цахилгаан станцын дэргэдэх Эрчим ҮЭ-ийн хороо мэндчилж байгааг хүлээн авна уу.

Тус хороо нь 2024.07.04 өдөр үүсгэн байгуулагчдын тогтоолоор улсын бүртгэлд бүртгүүлж, дүрмээ албан ёсоор баталгаажууллаа. Эрчим үйлдвэрчний эвлэлийн хорооны дүрмийг бид нээлттэй тавьсан байгаа. Цаашид гишүүдийнхээ саналд үндэслэн, хэлэлцүүлж тасралтгүй сайжруулах зарчмаар хэрэгжүүлнэ.

Дүрэмд ҮЭ-ийн байгууллагын үйл ажиллагааг оновчлоход ач холбогдол бүхий зохицуулалтуудыг оруулсан.

1. Тухайлбал хорооны үйл ажиллагааг 3 түвшинд тодорхойлсон. Бүх гишүүдийн хурал, ҮЭ-ийн үндсэн чиг үүрэг, гишүүдийн санал, оролцоог хангах гэсэн уялдаатай харилцааг тодорхойлсон. Үүнийг бүрэн хангахад дүрмийн зорилго оршино. /Дүрмийн 3.2: Үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалтын схем/



2. Бүх гишүүдийн хурал нь төлөөллүүдийг сонгох болон дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах дээд эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Мөн ҮЭ-ийн гишүүн бүр "Шууд хяналт"-ыг тавих боломжтой. Үүний тулд мэдээллийн нээлттэй, ил тод байдал хангагдсан байх шаардлагатай. Шууд хяналтыг хэрэгжүүлэх хэрэгсэл, механизм бүрдсэн гэж үзвэл "Хяналтын зөвлөл"-ийн төлөөллийг сонгохгүй байж болно. Энэ нь технологийн дэмжлэгээр цомхон, чанартай бүтцийг бүрдүүлэх, гишүүдэд дээд эрх мэдлийг бүрэн олгох зорилготой.
3. Дүрэмд удирдах ба гүйцэтгэх чиг үүргүүдийг шатлан хуваарилсан /тэргүүлэгчид болон хороон даргад/. Энэ нь төлөөллүүдийн ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хүнээс хамаарсан алдааг багасгах, хяналтын тогтолцоог сайжруулах, мөн харилцан зөвшилцсөн, хэлэлцүүлсэн шийдвэр гаргалтыг дэмжих тогтолцоог бүрдүүлсэн.
4. Хорооны үйл ажиллагааг зөвхөн дүрмээр зохицуулаагүй. Дүрэмд заасан үндсэн үйл ажиллагааг явуулахдаа бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны журам, гэрээ ба хэлцэл гэсэн

эрх зүйн баримт бичгүүдээр үйл явцыг тодорхой зохицуулахаар тусгасан. Энэ нь гүйцэтгэлийг чанартай, найдвартай зохион байгуулахад дэмжлэг болно.

5. Хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, дэмжихдээ ямар үнэ цэнийн зураглалаар хүрэх вэ? гэдгийг тодорхой болгож, бодлогын баримт бичгийг дүрэмдээ тусгасан. Энэ нь ҮЭ-ийн хороог замаасаа хазайхгүй, олон санаа оргож босохгүй, төлөвлөгөөтэй ажиллахад чиглүүлнэ.
6. Эрчим ҮЭ-ийн гишүүд нь "Бүх гишүүдийн хурал"-аар дээд эрх мэдлийг хэрэгжүүлэхээс гадна "Идэвхтэн гишүүн", "Чөлөөт зөвлөл"-ийн бүтэц зохион байгуулалтаар дамжуулан ҮЭ-ийнхээ бүхий л түвшний үйл ажиллагаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжтой, мөн түүнийгээ үнэлүүлж, идэвхтэй оролцооны урамшууллаа эдлэх зөв дугуй тасралтгүй хөгжлийн үйл явцыг тусгасан.
7. Сонгуульт хугацаа, давтамжийн хэм хэмжээг хариуцлагажуулсан.
8. ҮЭ-ийн хорооны санхүүжилтийн татварын хэмжээг үндсэн цалингийн 1%-иар тогтоож, цалингаас тооцох татварын хэмжээг гишүүдийн цалин хөлсний хэмжээнээс хамаарч 50% болон түүнээс дээш хувиар бууруулсан. Үр дүн нь ҮЭ-ийн хорооны үйл ажиллагааг зорилтод чиг үүрэг рүү төвлөрүүлэх, их хөрөнгө дагасан ашиг сонирхлыг бууруулах, ҮЭ-ийн нийтлэг татварын жишгийг бууруулах, гишүүдийнхээ татварын ачааллыг багсгах зэрэгт дэмжлэг болно.

Эрчим ҮЭ-ийн хороо нь байгуулагдсанаас хойш 2 сарын хугацаанд дүрмийнхээ хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хийж байна. Үүнд:


1. Гишүүдээ ил тод, шударга, нээлттэй мэдээллээр хангах, шилэн дансны хяналтын орчныг бүрдүүлэх, түүнчлэн цаг хугацаа, орон зай харгалзахгүй бүх гишүүдийн тэгш оролцоог хангах мэдээллийн системийг бий болгох дээр ажиллаж байна.
2. Хорооны ажлын үр дүнтэй, цэгцтэй зохион байгуулж, тогтворжуулахад зорилт бүхий бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны журам, ажлын гүйцэтгэлийн гэрээ боловсруулах зэргээр дотоод хэм хэмжээгээ тогтоож байна.
3. Гурван талт түншлэлийн эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээрт саналаа өгөхөөр бэлтгэж эхэлсэн. Үүнд, санал боловсруулах түр хороог байгуулан ажиллана.

Цаашид Эрчим ҮЭ-ийн хороо хамтын хэлэлцээрийн түвшинд станцын ажилтнуудынхаа хөдөлмөрлөх нийтлэг эрх ашгийг дэмжих асуудлуудыг шийдвэрлэхэд статистик судалгаа, шинжлэх ухаанч үнэлгээ дээр суурилсан, үндэслэл бүхий саналуудыг уламжлан, хэрэгжүүлэхээр томоохон ажлууд төлөвлөж байна.

Бидний хамтын эв санаа, хүчин чармайлт үргэлж бат бэх байх болтугай. Та бүхэндээ ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Эрчим ҮЭ-ийн хороотой холбоо барих: 98407777
 Эрчим үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга:
 Ж.Энхзул

УУШГИНЫ АРХАГ БӨГЛӨРӨЛТ ӨВЧИН



Уушгины архаг бөглөрөлт өвчин нь нийгмийн тулгамдсан асуудал төдийгүй дэлхийн хүн амын архаг өвчлөл болон нас баралтын томоохон шалтгаан юм. Дэлхий даяар уушгины архаг бөглөрөлт өвчний

хүндрэлүүд ирэх арван жилд өсөх хандлагатай байгаа нь хүн амын насжилт, уг өвчний эрсдэлт хүчин зүйлсийг үргэлжлүүлэн судлах шаардлагатай байгааг харуулж байгаа юм. Монгол улсад 2018 оны байдлаар 10000 хүн амд ноогдох халдварт бус өвчлөлийн шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин нэгдүгээр байрыг эзэлжээ. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны дотор амьсгалын тогтолцооны эмгэг 10000 хүн амд 456.1 тохиолдлоор нэгдүгээрт бүртгэгдсэн байна. Иймд амьсгалын эрхтэний эмгэгийг эрт илрүүлж, эмчийн хяналтанд авч эмчилгээ хийлгэснээр уушгины архаг бөглөрөлт өвчин, түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлнэ.

Уушгины архаг бөглөрөлт өвчин гэдэг нь архаг үрэвслийн улмаас агаар дамжих зам ба цулцанд бүтцийн өөрчлөлт гаран агаарын урсгал тогтвортойгоор хязгаарлагдах шинжээр илэрдэг урьдчилан сэргийлэх, эмчлэгдэх боломжтой элбэг тохиолддог өвчин юм.

Эрсдэлт хүчин зүйлс:

- Тамхидалт
 - Тамхины хэрэглээ (бүх тохиолдлын 90%)
 - Тамхинаас гараад ≥ 10 жил болсон үед эрсдэл нэмэгдэхгүй
 - Дам тамхидалт нь УАБӨ болон гуурсан хоолойн багтраа өвчнөөр өвдөх эрсдэл өндөртэй.
- Агаарын бохирдол / утаа, хорт хий/
- Мэргэжлийн таагүй нөлөө / органик ба органик бус тоосонцор/
- Олон дахисан амьсгалын замын халдвар, хууч өвчин
- Нас /45-аас дээш нас/
- Эмэгтэй хүйс

Эмнэл зүйн шинж тэмдэг:

Амьсгаадалт /үргэлж нэмэгдэх хандлагатай, эхэн үедээ ачааллын үед амьсгаадалт илэрдэг байсан бол сүүлдээ тайван үед амьсгаадах/, цээж шуугих, бачуурах, архаг ханиалга, удаан хугацаанд цэр гарах /цэртэй ханиах/ ба энэ өвчний сэдэрлэл голдуу хүйтэн сэрүүний улиралд илэрнэ.

Оношлогоо:

- Уушигны үйл ажиллагааны сорил (PFT)

Спирометр – Хамгийн чухал шинжилгээ /Гадаад амьсгалын үйл

ажиллагааны шинжилгээ/

- Гуурсан хоолойн тэлэх эмийн сорил
- Цусны хийн шинжилгээ болон пульс оксиметр
- Дүрс оношилгоо
- Бусад шинжилгээ /ЦДШ, зүрхний бичлэг/

Ялган оношлогоо:

Гол ялган оношлох эмгэг нь астма юм. Адил зовиур илэрдэг зарим өвчний онцлог шинжийг харуулбал:

Онош	Онцлог шинжүүд
Уушгины архаг бөглөрөлт өвчин	<ul style="list-style-type: none"> • Дунд эргэм насанд илэрнэ. • Шинж тэмдэг аажим даамжирна. • Тамхи татдаг эсвэл бусад төрлийн утаанд өртдөг өгүүлэмжтэй.
Астма	<ul style="list-style-type: none"> • Ихэвчлэн хүүхэд насанд эхэлдэг. • Шинж тэмдэг өөрчлөгдөх, хувьсах шинжтэй. • Удамшлын өгүүлэмжтэй • Таргалалттай. • Зовиур шөнө эсвэл үүрээр ихсэх хандлагатай.
Гуурсан хоолойн тэлэгдэл	<ul style="list-style-type: none"> • Их хэмжээний идээт цэр гарах • Ихэвчлэн бактерийн халдвартай холбоотой • Рентген, КТ-ийн шинжилгээгээр оношлогдоно.
Сүрьеэ	<ul style="list-style-type: none"> • Бүх насанд илэрнэ. • Рентген, микробиологийн шинжилгээгээр оношлогдоно.

Урьдчилан сэргийлэлт:

- Тамхины хэрэглээг зогсоох
- Томуу өвний эсрэг вакцин жил бүр хийлгэх
- Агаарын бохирдлоос зайлсхийх
- Амьсгалын замын цочмог үрэвслийг цаг тухайд нь төгс эмчлүүлэх
- Ажлын нөхцлийг солих
- Биеийн тамираар хичээллэх

Хүндрэл:

- Амьсгалын архаг дутагдал
- Цочмог сэдэрлэл
- Уушгин зүрх
- Хоёрдогч пневмоторакс үүсэх

Ашигласан ном материал: Эрүүл мэндийн сайдын тушаал, Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношлогоо, эмчилгээний удирдамж

/Эмнэлэгийн хэсэг/

That Might Motivate You №22

